

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД, ДОТООД ОРЧИН,
ХӨГЖЛИЙН ЯВЦ БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА, ДҮГНЭЛТ,
ЦААШИД БАРИМТЛАХ БОДЛОГЫН АСУУДЛУУД**

(СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ)

ГҮЙЦЭТГЭСЭН:

АЖЛЫН ХЭСЭГ

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

Д.ЧИМЭДДАГВА

Ц.НОРОВДОНДОГ

Улаанбаатар хот

2013 он

Contents

А.СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ.....	3
Нэг. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН, ГАДААД ХАРИЛЦААНД АНХААРАЛ ХАНДУУЛАХ АСУУДЛУУД.....	3
Хоёр. ТОМООХОН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ЯВЦ, АНХААРАЛ ХАНДУУЛАХ АСУУДЛУУД	10
Гурав. ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАЙДАЛ, ЦААШИД АНХААРАХ АСУУДЛУУД	12
Дөрөв. МАКРО ЭДИЙН ЗАСАГ БАЙДАЛ, ЦААШДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	14
Тав. БАЙГАЛЬ ОРЧИН НОГООН ХӨГЖИЛ, ЭРҮҮЛ МЭНД, ЯДУУРАЛ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ БУСАД АСУУДЛУУД.....	20

А.СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Нэг. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН, ГАДААД ХАРИЛЦААНД АНХААРАЛ ХАНДУУЛАХ АСУУДЛУУД

1. Гадаад эдийн засгийн орчин

Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн төлөв байдал тогтворгүй, хэтийн хандлага нь тодорхойгүй байна. Дэлхийн эдийн засгийн бодит өсөлт үргэлжлэн удаашрахад хөгжсөн орнуудын өсөлт мэдэгдэхүйц буурч, хөгжиж байгаа орнуудын гадаад эрэлт багасч байгаа нь нөлөөлөхийн зэрэгцээ дэлхийн аж үйлдвэрлэлийн өсөлт өндөр биш, ойрын хугацаанд сэргэлт нь удаан байх төлөвтэй байна. АНУ, Евро бүсийн эдийн засагт нүүрлэсэн асуудал нь богино хугацаанд шийдвэрлэгдэх хялбар асуудал биш бөгөөд дэлхийн эдийн засаг, аж үйлдвэрлэлийн өсөлтийг цаашид удаашруулах сөрөг үр дагавартай байж болзошгүй юм.

Евро бүсийн эдийн засгийн өсөлт зогсонги болж, аж үйлдвэрлэл нь Европын дийлэнх орнуудад, тэр ч байтугай Европын холбоог тэргүүлэгч Герман улсад ч буурсан үзүүлэлттэй байна. Эдийн засаг нь ийнхүү доройтохын сацуу Евро бүсийн банкуудын активын чанар муудаж, чанаргүй зээлийн хэмжээ болон чанаргүй зээлийг нийт олгосон зээлд харьцуулсан харьцаа ялангуяа Испанийн банкуудад огцом өсөлттэй байлаа.

Ийнхүү Евро бүсийн эдийн засгийн хямралтай нөхцөл байдал, Хятадын болон Азийн бүс нутаг дахь хөрөнгө оруулалтын орчны тодорхой бус байдалтай уялдан 2012 онд Хятадын экспортын эрэлт буурахын сацуу дотоодын эрэлт, хэрэглээ нь дорвитой өсөөгүйгээс эдийн засгийн өсөлт нь саарч 7.8 хувьд хүрсэн юм¹. Roubini судалгааны институцийн 2013 оны 4 сард шинэчилсэн таамаглалаар манай улсын экспортын гол түнш БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийг 2013 онд 7.6 хувьтай байна гэж үзсэн нь 2012 оны 7.9 хувийн өсөлтөөс буурсан үзүүлэлт болохоор байна. Мөн БНХАУ-ын аж үйлдвэрийн салбарын өсөлт өнгөрсөн оны сүүлийн хагасаас буурч 2012 оны 8 дугаар сард 8.9% буюу хамгийн доод түвшинд хүрээд 9 дүгээр сараас сэргэсэн хэдий ч, олон жилийн дунджаас доогуур түвшинд хэвээр байна.

АНУ-ын хөнгөн аж үйлдвэрлэлийн индекс болон түрүүлэгч индикатор харьцангуй эерэг үзүүлэлттэй гарах болж, хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй зэрэг эерэг өөрчлөлтүүд гарч байгаа хэдий ч, гадаад худалдаа, урсгал тэнцэл, улсын төсвийн алдагдал мэдэгдэхүйц буурахгүй, улсын өрийн үлдэгдлийн хэмжээ тасралтгүй өссөн хэвээр байгаа юм.

ОХУ-ын гадаад эрэлт буурсан, экспортын бүтээгдэхүүний үнэ дорвитой өсөөгүй, нийт мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарсан, урсгал тэнцлийн ашиг багассан, эдийн засгийн түрүүлэгч индикатор өнгөрсөн оны 8 дугаар сараас бууралттай гарч эхэлсэн, хэрэглэгчийн итгэлийн индекс муудсаар байсан зэрэг нь эдийн засгийн бодит өсөлт 2012 онд 3.4% болоход нөлөөлжээ.

¹ Экспорт болон хөрөнгө оруулалтаар удирдагдсан эдийн засгийн өсөлтийг хэрэглээнд суурилсан өсөлт болгон хувиргах шаардлагатай ч, Хятадад дотоодын хэрэглээнд мэдэгдэхүйц өсөлт гарахгүй байна.

2. Эрдэс түүхий эдийн зах зээлийн төлөв

Ойрын хугацаанд дэлхийн зах зээл дээр зэсийн үнэ төдийлөн өсөхөөргүй байна. Дэлхийн эрдэс бүтээгдэхүүн, түүхий эдийн зах зээл дэх голлох хэрэглэгч-нөлөөлөгч Хятад улсын стратегийн зэсийн нөөцийн түвшин 2009 оны хямралын дараа мэдэгдэхүйц буурсан бөгөөд 2011 оны дунд үеэс зэсийн нөөцлөлтийг дахин нэмэгдүүлж, улмаар хангалттай түвшинд хүргэж чадсан. Зэсийн үнэ буурч, тонн нь 7200 орчим ам.долларт тогтворжсон нь нэг талаас дэлхийн эдийн засаг, аж үйлдвэрлэлийн өсөлтийн удаашралаас, нөгөө талаас нийлүүлэлтийн хүчин зүйл буюу дэлхийн томоохон зэсийн уурхайнуудын олборлолтын хэмжээ бага, дэлхийн зэсийн зах зээлийн илүүдэл нэмэгдэх төсөөлөлтэй байгаатай холбоотой юм.

Монголын экспортын нүүрс, төмрийн хүдрийн үнэд мэдэгдэхүйц өсөлт 2013 онд гарахааргүй, өнөөгийн түвшинд тогтвортой байх хүлээлттэй байна. Хятадын орон нутгийн зах зээл буюу Хебей, Таншань, Шандонг, Зибо, Ченгде, Киндао зэрэг бүс нутаг дахь болон Тианжин зэрэг Хятадын голлох боомтуудаар импортолсон төмрийн хүдрийн үнэ 2011 оны 9 дүгээр сарын дунд үеэс эхлэн унаж эхэлсэн. Харин 2012 оны хоёрдугаар улирлаас эхлэн Хятадын Шинхуангдао, Шанхай, Тианжин, Тайюань боомтууд дээрх нүүрсний үнэ болон МакКлоски Шинхуа коксжих болон эрчим хүчний нүүрс, Пингдиншань дахь коксжих нүүрс, 2 дугаар зэрэглэлийн коксжих нүүрс, 1 дүгээр зэрэглэлийн металлургийн кокс, Австралиас Хятадад экспортолсон коксжих нүүрс, брикетний үнэ бүгд буурах хандлагатай болсон юм. Энэхүү уналт 2013 оны 1 дүгээр улирлыг дуусталх хугацаанд үндсэндээ үргэлжилсэн бөгөөд энэ оны 2 дугаар улирлаас үнийн уналт тогтворжсон.

3. Гадаад сектор, түүний дотоодын эдийн засаг дахь нөлөөлөл

2011 оны 4 дүгээр улирлаас эхэлсэн гадаад эдийн засаг, зах зээлийн орчны таагүй өөрчлөлт нь Монголын эдийн засагт (i) гадаад худалдааны нөхцөлийг муутгах, (ii) санхүүгийн дансны ашиг, тэр дундаа гадаадын шууд хөрөнгө оруулалтыг бууруулах гэсэн үндсэн хоёр сувгаар дамжиж сөрөг нөлөөлөл бий болгосноор 2012 онд эдийн засгийн бодит өсөлт өмнөх оны 17.5%-иас саарч 12.3% болох, мөнгө, зээлийн өсөлт, эдийн засгийн идэвхжил удаашрахад нөлөөлсөн.

Гадаад худалдааны нөхцөлийн жилийн өөрчлөлтийг 3 сарын гулсах дунджаар авч үзвэл 2011 оны 4 сараас эхлээд муудах хандлага ажиглагдаж, 2012 оны 4 дүгээр сараас нөхцөл байдал улам бүр ужгирсан байна. 2013 онд дэлхийн зах зээлийн тодорхойгүй байдал гүнзгийрч, Хятад улсын эдийн засаг, аж үйлдвэрлэлийн өсөлт үргэлжлэн саарвал манай улсын экспортын эрдэс түүхий эд, тухайлбал нүүрс, зэсийн баяжмал, цайр, төмрийн хүдрийн үнэ буурах, экспортын нүүрсний биет хэмжээ багасах эрсдлээс шалтгаалан эдийн засагт цэвэр дүнгээр орж ирэх валютын хэмжээ буурах, улмаар гадаад худалдааны алдагдал нэмэгдэж болзошгүй.

Сүүлийн 3 жилд урсгал тэнцлийн алдагдал тогтмол өссөөр 2012 онд ДНБ-ий 32 хувьтай тэнцэх хэмжээнд хүрсэн нь машин тоног төхөөрөмж, түлш шатахуун, удаан эдэлгээтэй, хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импортын өсөлт, гадаадаас авах үйлчилгээ, тэр дундаа тээврийн үйлчилгээний зардлын өсөлт, гадаадын хөрөнгө оруулалттай компанийн орлого, ногдол ашгийн шилжүүлэг буюу орлогын дансны алдагдлын өсөлтөөр тайлбарлагдаж байлаа. Гэхдээ урсгал тэнцлийн алдагдал нь хөрөнгө ба санхүүгийн дансны ашгаар бүрэн санхүүжигдэж байсан нь 2010-2011 онуудад гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж байв.

2013 он гарснаас хойшхи хугацаанд гадаад секторын таагүй, эрсдэлтэй нөхцөл байдал үргэлжилсэн хэвээр байна. Оны эхний улирлыг 2012 оны мөн үетэй харьцуулбал гадаад худалдааны нөхцөл 19.1 хувиар муудсан, экспорт 7.8 хувиар буурсан, гадаадын шууд хөрөнгө оруулалт 12 хувиар багассан, хөрөнгө ба санхүүгийн дансны ашиг 3.3 дахин буурч урсгал тэнцлийн алдагдлыг бүрэн санхүүжүүлж чадахгүй болсноос төлбөрийн нийт тэнцэл 387.4 сая ам.долларын алдагдалтай гарсан байна.

Монгол Улсын хувьд урсгал тэнцлийн тогтворгүй байдлын эрсдэл өндөр хэвээр байна. Урсгал дансны алдагдлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ өндөр, урсгал дансаар орж ирэх валютын урсгал (экспорт, үйлчилгээний орлого, хүүний орлого, хувийн шилжүүлэг) төдийлөн тогтвортой бус, нийт экспортын орлого нь ашигт малтмалын түүхий эдээс бүрдсэн бөгөөд гадаад зах зээл, БНХАУ-ын эрэлтээс шууд хамааралтай, ашигт малтмалын бус бүтээгдэхүүний экспорт өсөлтгүй, импортыг орлох үйлдвэрлэлийн хөгжил зогсонги, хэрэглээнд суурилсан эдийн засгаас үйлдвэрлэлд суурилсан эдийн засагт шилжих шилжилт удаан байгаа зэрэг нь урсгал дансны алдагдал мэдэгдэхүйц буурахгүй байх, тогтворгүй болох, дотоодын эдийн засгийн эмзэг байдлын эрсдлийг нэмэгдүүлж байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх эцсийн хэрэглээний хувийн жин тогтвортой өндөр түвшинд байна. Эдийн засгийн хурдацтай өсөлтийн үед Засгийн газар, хувийн хэвшил, өрхийн хөрөнгө оруулалт, хуримтлалаас илүүтэйгээр хэрэглээ нэмэгдэх хандлага даамжирвал урсгал тэнцлийг урт хугацаанд тогтворгүйжүүлэхэд нөлөөлөх эрсдэлтэй юм.

Цаашид гадаад секторын эрсдэл буурахгүй, экспортын эрдэс түүхий эдийн үнэ сэргэхгүй, гадаадын шууд хөрөнгө оруулалт өсөхгүй тохиолдолд гадаад секторын эрсдлийг төгрөгийн гадаад валюттай харьцах ханшид шингээхгүй бол төлбөрийн тэнцэл буюу гадаад валютын улсын нөөцөд ирэх дарамт өсөх эрсдэлтэй байна.

Иймд ашигт малтмалын томоохон төсөл хэрэгжүүлэх замаар экспортыг нэмэгдүүлэхийн сацуу экспортын төрөлжилтийг хангах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх хүрээнд ашигт малтмалын бус салбарын экспортыг урамшуулах цогц бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, нийгмийн дундаж давхаргын хуримтлалыг нэмэгдүүлэх шаардлага гарч байна.

4. Гадаад зээлийн ашиглалт, гадаад, дотоод өрийн байдал

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл сүүлийн жилүүдэд тогтмол нэмэгдэж байна. 2012 оны эцсийн байдлаар Монгол Улсын нийт гадаад өр 15.3 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 59 хувиар буюу 5.6 тэрбум ам.доллараар өссөн. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын гадаад өрийн түвшин нэмэгдэхэд Засгийн газрын бонд болон Засгийн газрын баталгаатайгаар олон улсад арилжаалсан бонд, уул уурхайн том төслүүдийн хөрөнгө оруулагчаас авсан зээлийн дүн нөлөөлжээ. *Урсгал дансны ирээдүйд бий болох ашиг нь гадаад өр төлбөрөө төлөхөд хүрэлцэх хэмжээтэй байх нь урт хугацаанд эдийн засаг тогтвортой байх нэг шалгуур болдог. Тиймээс урсгал дансны алдагдалтай зэрэгцэн, гадаад өрийн түвшин нэмэгдэж байгаа нь урт хугацаандаа эдийн засгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэхээр байна*

ОУВС, Дэлхийн банкны зүгээс 2010, 2011 онуудад хийгдсэн “Монгол Улсын гадаад өрийн тогтвортой байдлын шинжилгээ”-ний үр дүнгээр манай улс “өрийн хүндрэлийн эрсдэл багатай” гэсэн ангилалд багтаж байсан. Хөгжлийн банк, Засгийн газрын зүгээс гаргасан гадаад бондын нөлөөгөөр 2012 онд Засгийн газрын өрийн бүтэц, хэмжээнд ихээхэн өөрчлөлт гарсан бөгөөд Сангийн яамнаас 2013 онд хийгдсэн “Урт хугацааны төсөөлөлд үндэслэсэн

Гадаад өрийн тогтвортой байдлын шинжилгээ”-ний үр дүнгээр дээрх ангиллаас нэг шат бууран **“Өрийн хүндрэлийн эрсдэл дундаж”** гэсэн ангилалд багтаж байна.

Нэг жилийн дотор нийт өрд эргэн төлөгдөх өрийн эзлэх хэмжээ 2010 онд 3.1 хувь байсан бол 2012 онд 11.9 хувь болж өссөн, харин нийт өрийн эргэн төлөгдөх дундаж хугацаа 2011 онд 13.5 жил байснаас 2012 онд 11.9 жил болтол буурсан нь гадаад, дотоодын өрийн хувьд дахин санхүүжилтийн эрсдэл өмнөх онуудаас эрс өссөн байгааг харуулж байна.

Улс орнуудад энэхүү эрсдэл бий болсноор зээлийн эргэн төлөгдөх дундаж хугацаа богиносгох, улс орны зээлийн зэрэглэл буурч, шинээр зээлийн эх үүсвэр хомсдох, нэг жилд ногдох өрийн үйлчилгээний төлбөрийг санхүүжүүлэх эх үүсвэргүй /валютын нөөц, мөнгөн хөрөнгө гэх мэт/ болох зэрэг шинж тэмдгүүд илэрдэг бөгөөд Монгол Улсын хувьд эхний хоёр шинж тэмдэг саяхнаас илрээд байна.

Олон улсын зээлжих зэрэглэл тогтоодог Стандарт энд Пүүр (S&P) компаниас Монгол Улсын зэрэглэлийг “тогтвортой”-оос “сөрөг” болгон бууруулсан байна. Үүний үндэслэл нь “Засгийн газрын зээллэгийн болон хөрөнгө оруулалтын бодлого, бизнесийн орчин хангалтгүй” гэжээ.

Засгийн газрын гадаад өрийн үйлчилгээний эргэн төлөлтийн хуваариас харахад 2017 онд Хөгжлийн банкны бондын эргэн төлөлт, 2018, 2022 онуудад 1.5 тэрбум ам.долларын Евро бондын эргэн төлөлт тус тус хийгдэхээр хүлээгдэж байгаа нь томоохон хэмжээний дахин санхүүжилтийн эрсдэлийг бий болгож байна

Одоогийн хууль эрх зүйн тогтолцоо болох “Гадаадын зээл тусламжийн тухай” хуульд бодлогын асуудал тусгагдаагүй, зээллэг авах процедурын харилцааг зохицуулж, арилжааны нөхцөлтэй зээллэгийн удирдлага болон бусад санхүүгийн хэрэгслүүдийг ашиглах, зохицуулахад бодлого, зохицуулалтын шаардлага хангахгүй байна. Монгол Улсын эдийн засгийн худацтай өсөлт нь сүүлийн 20 жилд тулгарч байгаагүй шинэ нөхцөл байдлыг үүсгэж, өрийн тухай тогтсон ойлголтыг шинэчилж, санхүүжилтийн шинэ эх үүсвэр, арга хэрэгслүүдийг ашиглах, зөв зохистой удирдах урган гарч ирэх эрсдэлийг бууруулах талаарх хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн байх шаардлагатай байна.

5. Гадаад харилцаа, тулгамдаж буй асуудлууд

Манай гадаад эдийн засгийн хамтын ажиллагаанд хоёр хөрш орон тэргүүлэх байр суурь эзэлж ирлээ. Тухайлбал, 2012 оны байдлаар манай гадаад худалдааны 70 хувь, үүний дотор экспортын 93.7 хувь, импортын 54.5 хувь, 2011 оны байдлаар манай улсад орсон нийт хөрөнгө оруулалтын 20.5 хувь нь хоёр хөршид ногдож байна. Эдгээр үзүүлэлт нь манай улсын эдийн засаг цөөн тооны зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай байхаас сэргийлэх тухай Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын заалтад нийцэхгүй байгааг харгалзан тодорхой арга хэмжээ авч буй боловч энэ байдлыг ойрын хугацаанд өөрчлөхөд бодит хүндрэл тулгарсаар байна.

Түүнчлэн энэ хоёр орноос БНХАУ-тай хөгжүүлж буй худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа хэт давамгайлж байгаа тул хоёр хөрш оронтой бүхэлдээ тэнцвэртэй харилцах зарчим эдийн засгийн чиглэлд биелэхгүй байна. 2012 оны байдлаар манай экспортын 92 хувь БНХАУ-д, 2 хувь ОХУ-д, 2011 оны байдлаар хөрөнгө оруулалтын 20.4 хувь БНХАУ-д, 0.12 хувь ОХУ-д ногдож байна. Харин импортын хувьд аль алинд нь 27 хувь ногдож буй.

Сүүлийн жилүүдэд ОХУ, БНХАУ манай улсын уул уурхайн салбарт түлхүү анхаарах болсон бөгөөд тус салбарын томоохон төслүүдэд оролцох сонирхлоо илэрхийлж ирсэн. Тухайлбал, ОХУ Таван толгойн төсөл, мөн тус ордоос бүтээгдэхүүн тээвэрлэх төмөр замын бүтээн байгуулалтад оролцох сонирхлоо илэрхийлж ирсэн. БНХАУ Таван Толгойн нүүрсний орд, Гурванбулаг ураны ордыг ашиглах зэрэг уул уурхайн томоохон төсөлд оролцох сонирхолтой байна.

ОХУ-ын зүгээс сүүлийн жилүүдэд тавьж буй гол асуудал нь Таван толгойн ордыг ашиглах, тус ордоос бүтээгдэхүүн тээвэрлэх төмөр замын бүтээн байгуулалтанд оролцох асуудлыг шийдвэрлэх явцын хэрэгжилт удаашралтай байгаа, мөн Монгол-Оросын дээд, өндөр түвшинд тохирсон асуудлууд хэрэгжихгүй байгаатай холбогдуулан ОХУ-ын Ерөнхийлөгч хоёр талын хамтын ажиллагааны асуудлаар 2011 оны 8 сард захирамж гаргаж, манай талаас тавьсан “Улаанбаатар ТЗ” ХНН-ийн 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх асуудал, Төмөр замаар дамжих өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах, ОХУ-д төлөх өрийн асуудлуудын хэлэлцээг түр зогсоохоор шийдвэрлэсэн.

Монгол Улс Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтаас гаргасан судалгаанд өрсөлдөх чадвараараа дэлхийд 93-т орж байна. Далайд гарцгүй, хөгжиж буй орны хувьд манай улс экспортын бараа бүтээгдэхүүнээ хоёр хөршийнхөө нутгаар дамжин өнгөрүүлдэг бөгөөд ийнхүү тээвэрлэх нь тариф болон тарифийн бус саад тотгорын улмаас нэлээд өндөр өртөгтэй байдаг. Энэ нь манай бараа бүтээгдэхүүний үнэ өсөхөд нөлөөлж, өрсөлдөх чадварыг бууруулдаг. *Иймд манай улс дамжин өнгөрөх тээврийн асуудлаар хоёр хөрштэйгээ тус тус хэлэлцээр байгуулах буюу гурван талт хэлэлцээр байгуулах чиглэлээр урьд өмнө хийж байсан хэлэлцээгээ сэргээх нь нэн чухал байна.*

Цаашид хоёр хөрштэй тус тусад нь эдийн засгийн хамтын ажиллагаагаа бэхжүүлэхээс гадна Монгол, Хятад, Оросын гурван талын хамтын ажиллагаанд анхаарч, төмөр зам, авто зам, байгалийн хий, нефть, эрчим хүчний шугам гэсэн “5 шугам”-аар гурван улсыг холбох талаар судалж, тодорхой төслүүд хэрэгжүүлэх боломжтой юм.

Хоёр талын эдийн засгийн харилцаа улс төрийн харилцааны түвшнээс “хоцорч” байгаа тал ажиглагддаг. Энэ оны 2 дугаар сард шинэчлэн баталсан ОХУ-ын Гадаад бодлогын үзэл баримтлалд Монгол Улстай “уламжлалт найрсаг харилцаагаа бэхжүүлэх эрмэлзэлтэйгээ” илэрхийлсэн нь манай улстай харилцах талаар тусгай заалт орсон анхны тохиолдол болсон. Энэ нь 1990-ээд оноос хойшхи харилцан айлчлал, хамтарсан баримт бичгүүдэд туссан санаа боловч манай улстай харилцах асуудлыг ийнхүү тусгайлан заасан нь харилцаанд ач холбогдол өгч буйн илрэл мөн.

ОХУ-ын зүгээс сүүлийн жилүүдэд тавьж байсан гол асуудал нь Таван толгойн ордыг ашиглах, тус ордоос бүтээгдэхүүн тээвэрлэх төмөр замын бүтээн байгуулалтад оролцох асуудал билээ. ОХУ-ын Ерөнхийлөгч Д.Медведевийн 2009 онд Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр гарын үсэг зурсан хоёр улсын хооронд стратегийн түншлэлийг хөгжүүлэх тухай тунхаглалд “Тээврийн дэд бүтэц, уран болон ашигт малтмалын бусад орд газрыг ашиглах салбарын хамтарсан төслүүдийг зохих ёсоор урагшлуулах, эдгээр тохиролцоог хэрэгжүүлэх ажилд аль болохоор түргэн орох үүднээс шаардлагатай алхам хийхэд бэлэн байгаагаа талууд илэрхийлэв” гэж заасан. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн 2011 оны 5 дугаар сард ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэр гаргасан хамтарсан мэдэгдэлд “Монголын төмөр замын дэд бүтцийг байгуулах, шинэчлэх, ... Монголын баялгийн шинэ нөөцийг ашиглах, шинэ төмөр зам тавихтай холбоотой асуудлыг хамтарсан төслүүдийн хүрээнд нягт уялдаатай шийдвэрлэхийг зорьж байгаагаа мэдэгдэв” гэж тусгасан. Оросын тал энэ бүхнийг үндэслэн хоёр улс Монголын нутаг дэвсгэрт

байгалийн баялгийг ашиглах замаар шинэ төмөр замын дэд бүтцийг байгуулахаар тохирсон гэж үздэг байна.

Монгол-Оросын дээд, өндөр түвшинд тохирсон зүйлүүд хэрэгжихгүй байгаатай холбогдуулан ОХУ-ын Ерөнхийлөгч хоёр талын хамтын ажиллагааны асуудлаар 2011 оны 8 дугаар сард захирамж гаргаж, манай талаас тавьсан дараах асуудлын яриа хэлэлцээг түр зогсоохоор шийдвэрлэсэн. Үүнд:

- “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийг үүсгэн байгуулах тухай БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх,
- Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах,
- ОХУ-д төлөх өрийн асуудал.

Мөн саяхан Монгол Улсын Ерөнхий сайдыг энэ оны 3 дугаар сард ОХУ-д айлчлуулах асуудлыг манай талаас тавьсан боловч Оросын тал энэ айлчлалыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй, тухайлбал Таван толгой, төмөр зам зэрэг бүтээн байгуулалтын томоохон төслүүд дэх Оросын талын оролцоо тодорхойгүй, тохиролцоонд хүрээгүй байна гэсэн шалтгааныг хэлэв. Дээрх айлчлалыг хэрэгжүүлэх эсэх нь ОХУ-ын “РЖД” НХН-ийн Ерөнхийлөгч В.И.Якунины Монголд хийж буй айлчлалын үр дүнгээс шууд хамаарахыг Оросын тал мэдэгдсэн. **Ийнхүү Таван толгойн төсөл, төмөр замын бүтээн байгуулалт дахь ОХУ-ын оролцооны асуудал шийдэгдээгүй байгаа нь улс төр, эдийн засгийн харилцаанд бүхэлд нь нөлөөлж байна.**

ОХУ-ын дээрх захирамжид өртөөгүй боловч ахицгүй байгаа дараах асуудал харилцаанд мөн нөлөөлсөөр байна. Үүнд: 1) ОХУ-аас Монголд нийлүүлж буй нефть бүтээгдэхүүний асуудал, 2) Монгол, Оросын хамтарсан “Дорнод Уран” компанийг байгуулах тухай ЗГ хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх, 3) “Эрдэнэт” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах, 4) Монгол Улсад байгаа ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн асуудал зэрэг болно.

Иймд томоохон төслүүдэд хөрш орнуудын сонирхлыг тэнцвэртэй хангах асуудлаар ул суурьтай судалгаа хийж, төр, засгийн түвшинд хүрээнд бодлогын нэгдсэн ойлголтод хүрч, цаг алдалгүй шийдвэрлэх шаардлагатай байна.

Монгол, Хятадын стратегийн түншлэлийн харилцааны гол тулгуур нь худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа гэж талууд үздэг. Хоёр талын аж ахуйн нэгжүүд уул уурхай, барилга, зам, тээвэр, ХАА, банк, санхүүгийн салбарт эрчимтэй хамтран ажиллаж байна. Хятадын эрчимтэй хөгжлийг дагасан түүхий эдийн эрэлт манай улсын эдийн засаг огцом өсөхөд чухал үүрэг гүйцэтгэсэн. Нөгөөтэйгүүр, манай эдийн засаг Хятадын түүхий эдийн эрэлт, эдийн засгийн өсөлтөөс шууд хамааралтай хэвээр байна. Тухайлбал, БНХАУ-ын эдийн засгийн өсөлт саарсны улмаас Монгол Улсын нүүрсний экспортын хэмжээ буурч, эдийн засгийн өсөлт тооцоолж байснаас багассан билээ.

Эдүгээ манайд оруулсан гадаадын нийт хөрөнгө оруулалтын 32.7 хувь БНХАУ-д ногдож байна. **Уул уурхай, дэд бүтэц, санхүүгийн хамтын ажиллагааг цогцоор хөгжүүлэх зарчмаар хамтын ажиллагаа хөгжүүлэх, үлгэр жишээ болохуйц том төслүүдийг хэрэгжүүлэх саналыг Хятадын тал тусгайлан байнга тавьж ирсэн.**

Шинэчлэн батлагдсан Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд аль нэг орноос хийгдэх хөрөнгө оруулалтын хувь, хэмжээг гадаадын нийт хөрөнгө оруулалтын гуравны нэгээс

хэтрэхгүй байхаар тусгасан. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын энэ заалт болон Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг Хятадын эсрэг гаргасан зохицуулалт хэмээн Хятадын тал үзэж, хамтын ажиллагааны таатай орчин бүрдүүлэхийг хүсдэг. Иймд БНХАУ-тай эдийн засгийн хамтын ажиллагааг цаашид ямар хэмжээнд хөгжүүлэх талаар төр, засгийн түвшинд нэгдсэн ойлголтод хүрэх шаардлагатай байна.

Сүүлийн үед хоёр талын эдийн засгийн хамтын ажиллагаанд “Чалко” компанитай хийсэн гэрээг шинэчлэх асуудал хурцаар тавигдаж байна. Түүнчлэн Хятадын тал Таван толгой, Гурванбулагийн ураны ордыг ашиглах зэрэг уул уурхайн томоохон төсөл, төмөр замын бүтээн байгуулалтад оролцох сонирхлоо илэрхийлж ирсэн. Гэхдээ уул уурхайн салбар дахь хоёр талын хамтын ажиллагаа улс төрийн харилцаа, шийдлээс хамаарч байна.

Хятад нь дэлхийн эрдэс бүтээгдэхүүн, түүхий эдийн зах зээл дэх голлох хэрэглэгч-нөлөөлөгч орон бөгөөд манай улс дээрхи гэрээнээс шалтгаалан нүүрсээ гаргаагүй байхад ОХУ Хятад улс руу экспортлох нүүрсээ 20-25 хувиар нэмэгдүүлсэн байна. Дээрхи гэрээ хэлэлцээрүүд эцэслээгүй маргаантай байгаа нөгөө талаас манай улсын гэрээ, эрхийн хариуцлага сул байгаа нь зах зээл дэх байр сууриа алдах эрсдэлийг дагуулж байна.

БНХАУ-ын Тяньжин боомт дэлхийн зах зээлд хүрэх манай гол гарц болоод байна. Манай улс далайд гарах гарцаа нэмэгдүүлэх, гуравдагч оронд бараа, бүтээгдэхүүн экспортлох транзит тээврийн таатай нөхцөл бүрдүүлэх үүднээс Хятадын талд хоёр улсын хоорондын транзит тээврийн хэлэлцээрийг шинэчлэх санал тавьдаг.

Гуравдагч хөрш орнуудтай тогтоосон эдийн засгийн харилцаанд оршиж буй тулгамдсан асуудал, үнэлэлт, санал

Гадаад бодлогын үзэл баримтлалд зааснаар “АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх” нь манай гадаад бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг болно. Гуравдагч хөрш орнуудтай эдийн засгийн салбарт түлхүү хамтран ажилласнаар эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, эдийн засгийн бүх салбарт байгальд ээлтэй тэргүүний технологи, менежмент нэвтрүүлж, өрсөлдөх чадвараа дээшлүүлэн нэмүү өртөг шингэсэн экспортын хэмжээг өсгөхөд онцгой ач холбогдолтой. Мөн гадаадын хөрөнгө оруулалтыг татаж, ажлын байр нэмэгдүүлэхэд ихээхэн дөхөмтэй билээ.

Гуравдагч хөрш орнууд манай хоёр хөршийн адил уул уурхайн томоохон төслүүдэд оролцох сонирхолтой. Эдүгээ манай улсад хэрэгжиж буй уул уурхайн хамгийн том төслийг Австрали, Британийн Рио Тинто компани хэрэгжүүлж байна. Тиймээс ч энэ хоёр улсын Засгийн газар Оюу толгойн төслийн хэрэгжилтийг тусгайлан анхаарч, хөрөнгө оруулалтын орчноо тогтвортой байлгахыг манай талаас хүсдэг. АНУ-ын Засгийн газар Таван Толгойн нүүрсний уурхайн төсөлд АНУ-ын Пибоди Энержи компанийг оролцуулахад дэмжлэг үзүүлэхийг манайхаас бүх түвшинд албан ёсоор хүсч байна.

Сүүлийн үед гуравдагч хөрш орнуудын дунд манай хөрөнгө оруулалтын орчин тогтворгүй, эрсдэлтэй болсон гэсэн ойлголт бий болоод байна. Манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын хувьцааны үнэ нэлээд буурсан нь үүний нэг илрэл юм. Иймд хөрөнгө

оруулагчдын дунд үүссэн энэхүү ойлголтыг залруулах чиглэлээр бид дорвитой ажиллах шаардлагатай байна².

Улс орны эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой дараах томоохон төсөлд хоёр хөрш болон гуравдагч хөрш орнуудыг тэнцвэртэй оролцуулах асуудал эн тэргүүнд тавигдах болсон. Үүнд:

- Сайншандын хүнд аж үйлдвэрийн цогцолборт ган, коксжих нүүрс, хар төмөрлөг боловсруулах;
- Монгол Улсын төмөр замын сүлжээг өргөтгөн сайжруулах;
- Нефть, нефтийн бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдаж авах;
- Сайншанд, Дархан, Чойбалсан, Зүүнбаянд газрын тос боловсруулах үйлдвэр барих;
- Нүүрс хийжүүлэх, зэс хайлуулах үйлдвэр барих;
- Дулааны цахилгаан станц барих;
- Газрын ховор элемент хайх, олборлох.

Дээрхтэй холбогдуулан хоёр хөрш болон гуравдагч хөрш орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд монголын талын баримтлах байр суурийг нэгдмэл болгох, төр, засгийн байгууллагын ажлын уялдааг хангах шаардлагатай байна. Засгийн газраас энэ зорилгоор 2013 оны 1 дүгээр сард Монгол Улсаас гол түнш улстай хөгжүүлэх эдийн засгийн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэлийг хэлэлцэн баталсан байна.

Хоёр. ТОМООХОН ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ЯВЦ, АНХААРАЛ ХАНДУУЛАХ АСУУДЛУУД

Монгол улсын уул уурхайн салбар нь дунд хугацаанд эдийн засгийн өсөлтийг хангах гол хүчин зүйл болж байна. Гэвч уул уурхайн салбарыг цаашид хөгжүүлэхэд тээвэр, эрчим хүч, ус хангамж зэрэг дэд бүтцийн асуудлыг одоог хүртэл шийдээгүй байгаа нь томоохон хүндрэл болж байна. Тус салбарын бүтээгдэхүүний тээврийн зардал өндөр, хил гаалийн нэвтрүүлэх хүчин чадал сул, дамжин өнгөрөх тээвэр саад бэрхшээл ихтэй зэрэг нь тус салбарын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна. Сүүлийн жилүүдэд эрдэс бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ өсч, үнэ ханш нэмэгдсэнээр дэлхийн бусад орнуудад уул уурхайн төслүүдэд хөрөнгө оруулалт хийх, өмнө нь ашиггүй байсан төслүүд одоо ашиглах бололцоотой болсон зэргээс шалтгаалан тус салбарт өрсөлдөөн хурдтай нэмэгдсэн. Тухайлбал, АНУ, Канад, ОХУ зэрэг орнууд коксжих нүүрсний салбарт томоохон нийлүүлэгчдийн эгнээнд багтаж оров.

Уул уурхайн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхийн тулд хийгдэж байгаа борлуулалтын болон хөрөнгө оруулалтын гэрээнүүдтэй холбоотой асуудлууд ихээр гарч, тэдгээрийг сайжруулах чиглэлээр ажиллахад олон хүндрэл учирч, үүнээс шалтгаалж төслийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх үзэгдэл цөөнгүй гарч байна.

Үүнээс гадна, байгаль орчны стандартуудыг баримталдаггүй, олборлолтын болон бусад технологи муутай, нийгмийн хариуцлага хангалтгүй, байгаль орчныг ихээр сүйтгэдэг компаниудаас болж зөвшөөрөл, лицензийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох чиглэлээр байгаль орчин, уул уурхайн салбарт гарсан хууль эрх зүйн өөрчлөлтөд дэлхийн түвшний стандарт нэвтрүүлсэн, тэргүүний технологи бүхий, нийгмийн хариуцлага өндөртэй томоохон компаниуд өртөх тохиолдол цөөнгүй гарч байна.

² Гуравдагч хөрш орнуудын эдийн засгийн харилцааны талаар хавсралт 2-оос харна уу

Түүнчлэн, уул уурхайн томоохон төслүүдийн хэрэгжилтийн явцад болон хэрэгжиж эхлэхээс өмнө урьдчилгаа төлбөр хэлбэрээр улсын төсөвт орлого төвлөрүүлж байгаа нь тэдгээр компаниудад санхүүгийн хувьд хүндрэл үүсгэх, төслийн үр ашиг буурах зэрэг үзэгдэл гарч байгааг цаашид анхаарах нь зүйтэй. Мөн төрийн өмчит томоохон уул уурхайн төслүүдийн менежмент, компаний засаглал, хариуцлагын тогтолцоо сул байгаагийн улмаас өр болон авлага өсөх, бараа, материалын үлдэгдэл нэмэгдэх, улмаар санхүүгийн байдал хүндрэх тохиолдол гарч байна. Тухайлбал, Эрдэнэт үйлдвэрийн өглөг 2012 онд 2011 оноос 2 дахин, авлага 38 хувиар өсч, бараа, материалын үлдэгдэл сүүлийн 2 жилд 26 хувиар өссөн дүр зураг гарч байна. Иймд төрийн өмчит үйлдвэрүүдийн үр ашгийг дээшлүүлэх, удирдлага, менежментийг сайжруулах талаар далайцтай арга хэмжээ авах, санхүүгийн чадварийг сайжруулах, тухайлбал *тус үйлдвэрийн хувьд дунд хугацааны зээлийн найдвартай шугам нээж өгөх асуудал чухал юм.*

Эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэхэд дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх нь нэн тэргүүний чухал асуудал болоод байна. Уул уурхайн болон бусад салбарыг хөгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийг бий болгохоос гадна бүс нутаг, хот суурин газруудыг хөгжүүлэхэд зам, эрчим хүч, инженерийн дэд бүтцүүд барьж байгуулах нь хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэх, шилжих хөдөлгөөнийг бууруулахад ихээхэн дэмжлэг болох юм.

Уул уурхайн томоохон ордуудыг түшиглэсэн төмөр замын сүлжээ одоог хүртэл баригдаж эхлээгүй байгаагаас гадна одоогийн сүлжээ ачаа нэвтрүүлэх хүчин чадал бага, төмөр замын суурь бүтэц эзэмшигчдийн зүгээс тээвэрлэлтэд тавьдаг хориг саад их, төмөр замын тээврийн тарифын бодлого, тогтолцоо төлөвшөөгүй, үндсэндээ төмөр замын тээвэрлэлтийн үйл явцыг нарийн зохицуулсан эрхзүйн орчин бүрэн бүрдээгүй байна.

Өнөөгийн байдлаар Монгол Улсын хэмжээнд нийт 49.2 мянган км улсын чанартай авто замаас ердөө л 6 хувь нь хатуу хучилттай авто зам байгаа юм. Энэ нь өнөө цагийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүй байна. Иймд хатуу хучилттай авто замын сүлжээг өргөжүүлэх шаардлагатай байгаа бөгөөд Засгийн газрын зүгээс 2013 онд 6 аймгийн төвийг, 2014 онд 4 аймгийн төвийг, 2015 онд 2 аймгийн төвийг Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбохоор төлөвлөж байна. Сүүлийн жилүүдэд манай улс хатуу хучилттай авто зам барьж байгаа ч тэдгээр замын чанарт тавих хяналт сул байна. Мөн авто замын урсгал засвар, арчлалтад хөрөнгө бага тусгадаг учраас барьсан замын эдэлгээ, насжилт богиносоход нөлөөлж байна.

Томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд хөрөнгө санхүүгийн нөөц маш их шаардлагатай байгаагийн зэрэгцээ бага хэмжээний санхүүгийн нөөцийг нэн шаардлагатай тэргүүлэх төслүүдэд чиглүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

Хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх санхүүгийн нэг чухал эх үүсвэр нь Хөгжлийн банк бөгөөд банкны өөрийн босгосон хөрөнгө болон Чингис бондын хөрөнгийг тус банкаар дамжуулан Засгийн газраас тогтоосон төслүүдэд олгож байна. 2013 онд нийтдээ 1.8 их наяд төгрөгийн санхүүжилтийг хийхээр төлөвлөжээ. Чингис бондын хөрөнгөөр “Тавантолгойн цахилгаан станц”, “Гудамж”, “Шинэ төмөр зам”, “Аймгийн төвүүдийг Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбох”, “Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх”, “Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх”, “Өвлийн хүлэмж барих”, “Ноосон бүтээгдэхүүний үйлдвэр барих”, “Оёмол бүтээгдэхүүний салбарыг хөгжүүлэх” зэрэг төслүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хөгжлийн банкаар цаашид нэмэлт санхүүжилт олгоход одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд хэрэгжих боломжгүй болох эрсдэл байна. Иймд Хөгжлийн банкны өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх талаар шат дараатай арга хэмжээ авч улсын төсөвт тусгах асуудлыг судлаж үзэх шаардлагатай. Өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлснээр хуульд заасан өөрийн хөрөнгийн харьцаа сайжрахаас гадна Хөгжлийн банкны рейтингийг тогтоолгоход чухал ач холбогдолтой юм.

Одоогоор Хөгжлийн банкнаас олгосон зээлийн ерөнхий дүнгээс үзвэл Улсын төсвөөс эргэн төлөгдөх зээлийн хэмжээ төслийн орлогоос эргэн төлөгдөх дүнтэй харьцуулахад 72 хувьтай байгаа бөгөөд цаашид улсын төсвөөс эргэн төлөгдөх зээлийн нийт зээлд эзлэх хувь ихээхэн нэмэгдэхээр байгаа тул бизнесийн буюу өөрийн орлогоосоо эргэн төлөх төслүүдэд чиглүүлэх нь Хөгжлийн банкны үйл ажиллагаа болон бонд эргэн төлөхөд дарамтыг бууруулах сайн талтай.

Хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлэхэд улсын төсөв чухал эх үүсвэр бөгөөд сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлтийг дагаад хурдтай нэмэгдэж байна. Гэвч төслийн судалгаа, тооцоо, зураг төсөв муу хийгдэж байгаагаас хөрөнгө оруулалтын төлөвлөлт алдаатай болох үзэгдэл цөөнгүй гарч байгаагаас гадна төслүүдийн төсөвт сүүлийн жилүүдэд хурдтай өсч байгааг анхаарах хэрэгтэй.

Мөн барилгын ажлын зураг, төслийн даалгавар өгөхөөс эхлээд боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, тэдгээрт тавих бүхий л хяналтууд хангалалтгүй хийгдэж байгаагийн улмаас их хэмжээний хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үндсэн шалтгаан болж байна.

Гурав. ГАДААДЫН ШУУД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАЙДАЛ, ЦААШИД АНХААРАХ АСУУДЛУУД

Монгол дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын цэвэр урсгал 2012 онд буурахад дараах хүчин зүйлс нөлөөлсөн:

- Дэлхийн дахинд гадаадын шууд хөрөнгө оруулалтын урсгал 2012 онд 18%-иар буурсан (UNCTAD);
- Хятадын төрийн удирдлага өөрчлөгдөхтэй уялдан 2012 онд бүс нутгийн болон дэлхийн хөрөнгө оруулалтын орчинд тодорхой бус байдал үүссэн нь шинээр хөрөнгө оруулалт орж ирэхгүй байх үндсэн шалтгаан болсон;
- Евро бүсийн өрийн хямралт нөхцөл байдлаас шалтгаалж хөгжсөн орнуудаас бусад орнуудад хийх хөрөнгө оруулалтын хэмжээ эрс багассан;
- Хятадаас дэлхийн бусад оронд хийсэн хөрөнгө оруулалт 2012 онд \$79.7 тэрбум болж 6.9 хувиар өссөн боловч үүнээс хөгжиж буй болон бүрэлдэж буй эдийн засагтай орнуудад хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээ 49.7 хувиар буурч \$22.6 тэрбум болсон.
- “*Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай*” хуулийг 2012 оны 5 дугаар сард баталсантай уялдан бага хэмжээтэй³ хөрөнгө оруулалтын урсгал огцом буурсан.
- Оюу толгойн хөрөнгө оруулалт төслийн сүүлийн шатандаа орсон.
- Ерөнхийлөгчийн тамгын газраас Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлэлцэгдээгүй байгаа нь уул уурхайн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байсан зарим хөрөнгө оруулагчдад хүлээлт бий болгосон,

³ Монголбанкны тооцоогоор \$30 саяас доош хэмжээтэй гадаадын шууд хөрөнгө оруулалтуудыг энд ойлгоно.

- Чалко компанитай холбоотой асуудлын улмаас SGS компанийн хөрөнгө оруулалт үндсэндээ зогссон зэрэг болно.

Монгол Улс руу чиглэсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 2000 оноос аажмаар өсөх хандлагатай явж ирсэн. Харин 2009 оноос энэ хэмжээ огцом нэмэгдэж, 2010 онд 1 тэрбум ам.доллар, 2011 онд 4.7 тэрбум ам.долларт хүрсэн нь Оюутолгой төсөл болон уул уурхайн салбарт хийгдэж байгаа хөрөнгө оруулалттай холбоотой юм. Төрийн байгууллагуудын нэг хэсэг, хувийн секторт тоглогчид нь гадаадын хөрөнгө оруулалтыг татах тал дээр ихээхэн хүчин чармайлт гарган ажиллаж байхад нөгөө талд нь энэ хөрөнгө оруулалтыг үргээх бодлого, үйлдэл явагддаг байж болохгүй. Гадаадын хөрөнгө оруулагч нар Монголын хэвлэл мэдээллээр гарч байгаа бүх зүйлсийг нарийвчлан задлан, шинжилдэг тул цаашид төрийн эрх бүхий албан тушаалтан нар төрийн гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримталж буй бодлоготой нийцсэн мэдээллийг өгч байх шаардлагатай юм.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт бүтцийн хувьд ихээхэн өрөөсгөл байна. Нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 85 орчим хувь нь уул уурхайн салбарт оржээ. Энэ нь Монгол Улсын эдийн засаг, экспорт нь цөөн нэр төрлийн бүтээгдэхүүнээс хамаарсан бүтэцтэй болсны илэрхийлэл юм. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулагчийн гарал үүслээр авч үзвэл БНХАУ тэргүүлж, Нидерланд, Люксембург, Виржини Арлууд зэрэг дэлхий дахинд офшор хийдэг бүсүүд удаалж байна.

Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчин бусад орнуудтай харьцуулахад дундаж түвшинд байгаа хэдий ч, эрсдэлтэй гэсэн ангилалд байна. Татварын хувь хэмжээ, хориг тавьсан байдал, гаалийн тарифын босго зэргээр авч үзвэл Монгол Улсын зах зээл Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын хөгжиж буй орнуудын дундаж түвшинд байна. Дэлхийн өрсөлдөх чадварын тайлан-2012-д Монгол Улсад хөрөнгө оруулалт хийхэд Засгийн газрын хүнд суртал, ажиллах хүчний боловсролын түвшин харьцангуй бага, авилга, дэд бүтцийн салбар болон санхүүгийн салбарын хөгжил сул зэрэг асуудал хамгийн ихээр саад болж байна гэж үзжээ.

Манай Улсад хөрөнгө оруулалтыг дэмжсэн, урамшуулсан эсхүл хөнгөлөлт олгосон хууль бүрэн утгаараа одоогоор байхгүйн улмаас гадаадын шууд хөрөнгө оруулалтыг ангилан татах боломжгүй байна. Өөрөөр хэлбэл, *эдийн засгийн бүтцийг сайжруулах, олон төрөлт болгоход гадаадын шууд хөрөнгө оруулалтыг шаардлагатай салбар, үйлдвэрт болон хөдөө орон нутагт ялгавартай татах “урамшууллын” тогтолцоо байхгүй байна.*

Мөн гадаадын хөрөнгө оруулагч барилгын, үйлдвэрлэлийн, худалдааны салбарт хөрөнгө оруулсаныхаа дараа дахин хөрөнгө оруулах сонирхол дараахь шалтгааны улмаас буурах хандлагатай байдаг. Үүнд:1) татварын хууль тогтоомж тодорхойгүй, шийтгэх, торгох, яллахад чиглэдэг, 2) шүүгч нарын боловсрол дутмаг, иргэний эдийн засгийн шинжтэй маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхэд хүндрэлтэй байдгийн улмаас хөрөнгө оруулагч нар ихээр хохирдог байна.

Монгол Улс бол албан ёсоор фронттиер зах зээл буюу “эрсдэл өндөртэй зах зээл” гэсэн ангилалд, зээлжих зэрэглэл ВВВ-с доош буюу хөрөнгө оруулалт хийхэд хангалалтгүй гэсэн ангилалд байна. Иймд улсын зээлжих зэрэглэлийг нэгдсэн бодлогоор сайжруулахад анхаарах шаардлагатай байна. Хэрэв ВВВ буюу түүнээс дээш болгож чадвал энэ зэрэглэлтэй төслүүдэд хөрөнгө оруулдаг, хөрөнгө оруулалтын сангуудын нийтдээ 4.1 их наяд ам.долларын зах зээл нээгдэж, гадаадаас авах санхүүжилтийн өртөг даруй 100-с 350 пунктээр буурах болно.

Гадаадын хөрөнгө оруулалт бол аливаа улсын хөгжлийн гол хөдөлгөгч хүч байдаг тул цаашид Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих стратеги боловсруулж, хууль эрх зүйн орчингоо улам сайжруулж, гадаадын хөрөнгө оруулалт нэн шаардлагатай салбар, бүс нутагт оруулах хөрөнгө оруулалтыг урамшуулах тогтолцоог бий болгох нь зүйтэй.

Дөрөв. МАКРО ЭДИЙН ЗАСАГ БАЙДАЛ, ЦААШДЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

2012 онд макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт болох төлбөрийн тэнцэл, төсвийн алдагдал өмнөх жилүүдэд байгаагүй өндөр түвшинд хүрсэн нь мөчлөг дагасан төсвийн бодлого, ирээдүйн экспортын орлогоо барьцаалж авсан богино хугацаатай зээлээр санхүүжүүлсэн нийгмийн хавтгайрсан халамж буюу бэлэн мөнгө тараалт, гадаад секторын эрсдэлд өртөмтгий эмзэг байдал, эрдэс баялгийн салбараас хэт хараат байдал зэргээс шалтгаалсан. Нөгөө талаас макро эдийн засгийн нэгдсэн менежмент сул, төрийн байгууллага хоорондын уялдаа хангалтгүй байгаа нь тулгарч буй сорилт, хүндрэлийг түргэн шуурхай урьдчилан харж шийдэх боломжийг хязгаарлаж байна.

- *2012 онд ДНБ-ны өсөлт 12.3 хувь болж өмнөх оныхоос бага зэрэг саарсан боловч харьцангуй өндөр өсөлт юм. Уул уурхайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд дорвитой өсөлт гараагүй боловч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, санхүүгийн болон даатгалын салбарын өсөлт ДНБ-ны өсөлтөд нөлөөлсөн байна.*
- *Нэгдсэн төсвийн тэнцэл ДНБ-ны 8.4 хувьд хүрсэн нь анхаарал хандуулах асуудал болж байна. Хөгжлийн банкнаас эргэн төлөх нөхцөлгүй төсөлд санхүүжилт хийж байгаа нь төсөвт дарамт учруулахаар байна. Хөгжлийн банкны санхүүжилтийн нэгдсэн төсөвт оруулж тооцвол төсвийн нийт тэнцэл ДНБ-ны 10.4 хувь болохоор байна.*
- *Төлбөрийн тэнцлийн урсгал тэнцэлийн алдагдал 3.3 тэрбум ам доллар болсон нь ДНБ-ны 31.3 хувьд хүрсэн нь түүхэнд байгаагүй өндөр түвшин юм. Үүнд голлон нүүрсний экспорт 17 хувиар буурсан нь нөлөөлжээ. Мөн гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр урсгал 2012 онд 17 хувиар буурч, 3.8 тэрбум дол болсон.*

Болзошгүй хямралын эрсдэлтэй нөхцөл байдал бий болсон үед Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасыг өнгөрсөн оны 12 дугаар сард олон улсын зах зээлд арилжаалах замаар 1.5 тэрбум ам.долларын эх үүсвэрийг бүрдүүлсэн нь гадаад валютын улсын нөөцийг 4 тэрбум ам.долларт хүргэн нэмэгдүүлж, эдийн засагт, нийгэмд тогтворгүй байдал үүсэх эрсдлийг арилган, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах, улмаар 2013 оны эдийн засгийн харьцангуй тогтвортой суурийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой болсон билээ. Тухайлбал, 2012 оны сүүлийн хагаст төлбөрийн тэнцэл -602 сая ам.долларын алдагдалтай гарахаар байсан бол бондын энэхүү эх үүсвэр эдийн засагт орж ирснээр төлбөрийн нийт тэнцэл 1.4 тэрбум ам.долларын ашигтай гарч, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш огцом хэлбэлзэх, инфляци өсөх, улмаар эдийн засагт төлбөрийн тэнцэл, валютын ханшийн хямрал учирч, тэр нь санхүүгийн болон эдийн засгийн хямрал болж ч болзошгүй байсан эрсдлээс хамгаалахад чухлаар нөлөөлсөн юм⁴.

Сүүлийн 3 жилд уул уурхайн салбарын өсөлтийн улмаас гадаад худалдааны эргэлт ДНБ-ий хэмжээнээс давж, экспортын орлогын 93%-ийг эрдэс бүтэгдэхүүний орлого бүрдүүлэх болсноор манай эдийн засаг гадаад гэнэтийн шоконд улам өртөмтгий болж байна.

⁴ Монгол банк

- **Эдийн засгийн өсөлт 13-16 хувь өсөхөөр байгаа боловч эдийн засгийн тодорхойгүй байдал давамгайлж байгаагаас эдийн засгийн төлөв нэлээд тогтворгүй байна.** ОТ төслийн үйл ажиллагаа 6-р сараас эхэлвэл эдийн засагт томоохон өсөлт гарахаар байна. Мөн Чингис бондын эх үүсвэрээр (төмөр замын суурь бүтцийн санхүүжилтэд 200 сая ам дол, Таван толгойн уурхайг түшиглэн барих 450 МВт-ын цахилгаан станцад 50 сая ам дол-г ЗГ-аас зарцуулахаар төлөвлөсөн) санхүүжүүлэхээр төлөвлөсөн томоохон хөрөнгө оруулалт хийгдэж эхэлвэл эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцох шаардлагатай. (Эдийн засгийн шингээх чадвар, хувийн хэвшлийн оролцоо, инфляци гэх мэт). Бондын хөрөнгийг ашиглан хэрэгжүүлэх томоохон төслүүдийн хувьд төлөвлөлтийн бэлтгэл ажлыг хангаж, техник эдийн засгийн үнэлгээ хийхэд хугацаа шаардлагатай байгаа тул их хэмжээний хөрөнгө оруулалт түрүүлж гарах магадлал бага байна. Өсөлтийн хурдац эдийн засгийн үйлдвэрлэх хүчин чадлаас түрүүлж байгаа учраас Чингис бондын эх үүсвэрээр улсын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг нэмж санхүүжүүлэх нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг шахаж, эдийн засгийн өсөлтөд үзүүлэх үр нөлөө нь хязгаарлагдахын зэрэгцээ инфляцийн дарамт үүсгэж болзошгүй юм⁵. Мөн Дэлхийн зах зээлийн таагүй орчин, гол нэр төрлийн бүтээгдэхүүний үнийн бууралт, ОТ-н төслийн ажиллагаа хойшилох зэрэг нөлөөллүүд нь эдийн засгийн байдлыг өөдрөгөөр төсөөлөх боломжийг хязгаарлаж байна.
- **Төсвийн бодлого байнга тэлж, мөчлөг дагасан шинжтэй байгаа нь эдийн засаг тууштай, тогтвортой өсөхөд эрсдэл болсон хэвээр байна.** Дэлхийн зах зээл дээрх эрдэс бүтээгдхүүний үнийн өсөлтийн үед валютын орох урсгалын өсч нийт эрэлт нийлүүлэлтээс даван хэт өсч байсан бол, гадаад эдийн засгийн байдал сулрахад экспортын орлого буурч, гадаадын хөрөнгө оруулалт зогсч, эдийн засгийн халалтын үед гарсан их хэмжээний зээл эргэн төлөгдөхөд хүндрэл гарч байгааг өнгөрсөн хямралын туршлага бидэнд харуулсан. Төсвийн алдагдал ихээр хуримтлагдаж эхэлсэн энэ үед эрдэс баялагийн зах зээл дээр гэнэтийн цочрол үүссэн тохиолдолд Сангийн яам асуудлыг зохицуулан шийдвэрлэх боломж хязгаарлагдмал юм.
- **Нэгдсэн төсвийн орлогын хэт өндөр төсөөлөл, гадаад орчны таагүй орчиноос шалтгаалж тасарсан тохиолдолд төсвийн алдагдал 6-8 хувь болох магадлалтай байна.** Энэ нь өндөрөөр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө тасрах эрсдэлийг дагуулж байна. Төсвийн нийт орлогыг 7,258 тэрбум төгрөг буюу өмнөх оныхоос 28.9 хувиар өсөхөөр төлөвлөсөн. Төсвийн орлогыг тооцохдоо нийт экспортыг 78 хувь нэмэгдэхээр, үүнээс уул уурхайн олборлолт 60 хувиар өсөхөөр таамагласан. Ялангуяа 2013 онд ОТ 382 мянган тонн зэсийн баяжмал, 424 мянган унц алт, 802 мянган унци мөнгө үйлдвэрлэхээр төлөвлөсөн. Мөн ОТ гэрээнд өөрчилөлт оруулснаар 445 тэрбум төгрөг нэмэлт орлого орохоор төсөвлөсөн нэлээд эргэлзээтэй асуудал юм.
- **Төсвийн дээрхи байдлын зэрэгцээ Үнийг тогтворжуулах хөтөлбөр, Хөгжлийн банкны санхүүжилт, мөн Чингис бондын зарцуулалт төсөвт дарамт учруулахаар байна.** Засгийн газар олон улсын зах дээр зээллэг хийж, Чингис бондын хөрөнгийг босгосон бөгөөд энэ эх үүсвэрийг ашиглаж эхэлснээр төсвийн томоохон ачаалал үүсч, эдийн засагт нөлөөлөл бий болно. Иймд бондын хөрөнгийн ашиглалтыг эргэн төлөгдөх үр ашигтай төслүүдэд зарцуулах, төсөвт дарамт учруулахгүй байх асуудал нэн чухал.
- **Тогтворжуулалтын санд хангалттай хэмжээний эх үүсвэр бүрдээгүй байгаа нь түүхий эдийн бүтээгдэхүүний үнийн хэлбэлзлээс хараат хэвээр байгааг харуулж байна.** Төсвийн орлогыг голлон бүрдүүлэгч уул уурхайн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түүний татварыг нэлээд өсөлттэйгээр төлөвлөсөн нь гадаад эдийн засгийн таагүй нөлөөлөлийг бүрэн харгалзаагүй байна. Гадаад худалдааны алдагдал нэмэгдэж, экспорт, импортын хэмжээ буурахаар байгаа нь эдийн засгийн өсөлтийг сааруулахаар

⁵ Дэлхийн банк

байна. Мөн Оюу толгойн үйлдвэрлэл төлөвлөсөн хугацаанаас хойшилбол төсвийн орлогод сөргөөр нөлөөлөх магадлалтай.

- **Санхүүгийн салбарт тулгарч буй сорилтуудыг нэрлэвэл, нэгдүгээрт санхүүгийн зах зээлийн тэнцвэрт байдал алдагдсан, банкны салбар хэт давамгайлсан, хоёрдугаарт санхүүгийн зах зээл нь эдийн засгийн эрчимт өсөлтөө гүйцэлгүйгээр саад тотгор болох төлөв ажиглагдаж байна.** Монгол Улсын санхүүгийн зах зээлийн өнөөгийн зохицуулалтын бүтцийг харахад нийт санхүүгийн салбарын 4.4 хувийг Санхүүгийн зохицуулах хороо, үлдсэн 95.6 хувийг Монголбанк дангаараа зохицуулж байна.⁶ Монгол улсад банкны салбар хэт давамгайлсан энэ байдал нь ирээдүйд банкны салбарт үүссэн хүндрэл санхүүгийн секторт нөлөө үзүүлэх үр дагавартай тул санхүүгийн секторын хөгжлийг сааруулах, цаашилбал хямралд хүргэж болзошгүй юм.
- **Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын дийлэнхи нь алдагдалтай ажиллаж байна.** Салбарын өсөлтийг дэмжихүйц хууль тогтоомжийн тогтолцоо бүрэлдээгүй, зах зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээний сонголт хомс, үнэт цаасаар хөрөнгө татан төвлөрүүлэх зах зээлийн багтаамж бага, зах зээлд боломжит хэмжээнд шинэ бараа бүтээгдэхүүн нийлүүлэгдэхгүй байгаа нь нөлөөлж байна.

Макро эдийн засгийн нэгдсэн удирдлага сул, төрийн байгууллага хоорондын уялдаа хангалтгүй.

- **Монгол улсын эдийг засгийн сектор хоорондын (эдийн засгийн бодит салбар, төсөв, мөнгө, гадаад сектор) уялдааг хангасан макро эдийн засгийн загвар, түүнд суурилсан төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа, нэгдсэн бодлого үгүйлэгдэж байна.** Тухайлбал: Эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэн дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, эдийн засгийн өсөлтөд дотоод эрэлтийн оролцоог нэмэгдүүлэх, ялангуяа ЖДҮ-ийг дэмжих шаардлага нэн чухал асуудал болж байна. Манай эдийн засаг олон улсын санхүүгийн захаас өмнөхөөс илүү хамаарч, тэднээс эх үүсвэр татаж хөгжихөөр байна. Олон улсын санхүүгийн зах зээлийн ажиглагчид Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтэд анхаарал хандуулж байгааг тооцож макро бодлогын уялдааг хангах хэрэгтэй болжээ.
- **Макро эдийн засгийн байдлын судалгаа, нэгдсэн төлөвлөлт хийхдээ Үндэсний тооцооны нэгдсэн дансууд, салбар хоорондын баланс, төлбөрийн тэнцэлийн суурь үзүүлэлтүүд, Үндэсний нийт орлого, Түрүүлэгч индикатор, хэрэглэгчийн итгэлцлийн индекс зэрэг үзүүлэлтийг бодлогын түвшинд хэрэглэж, мөрдөх шаардлагатай байна.** Маш их цаг, хөдөлмөр зарцуулж эдгээр үзүүлэлтүүдийг тооцож байгаа боловч бодлогын түвшинд шийдвэр гаргахад эдгээр үзүүлэлтүүдийг ашиглах явдал хангалтгүй байна. Сүүлийн жилүүдэд гадагш чиглэсэн хөрөнгийн урсгалтай уялдан ДНБ болон ҮНО-н харьцаа нэлээд нэмэгдэх хандлагатай байгаа нь Үндэсний нийт орлогыг бодлогын түвшинд анхаарч судлаж байх шаардлагатай болж байна. Мөн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийн гүйцэтгэл гарахад хугацаа шаардагддаг тул макро эдийн засгийн загварт суурилсан прогноз, түрүүлэгч индикатор, хэрэглэгчийн итгэлцлийн индекс зэрэг олон улсын түвшинд ашиглаж буй үзүүлэлтүүдийг ашиглаж хурдан өөрчилөгдөж буй эдийн засгийн байдалд дүн шинжилгээ хийж цаг алдалгүй урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байх механизмыг бүрдүүлэх шаардлагатай байна.
- **Валютын захыг хямралаас сэргийлэх үндэсний механизмыг бий болгох хэрэгтэй болж байна.** Хөрөнгийн урсгалыг либеральчилж, хөрөнгө улс дамнан чөлөөтэй шилжих болсон өнөө үед урсгал дансны алдагдалтай хэдий ч хөрөнгийн дотогшлох урсгалыг нэмэгдүүлэх замаар валютын нөөцийг өсгөх боломжийг судлах хэрэгтэй. Монголбанк хямралаас урьдчилан сэргийлэх үндэсний бүтэц, механизмыг бий болгох ажлын хүрээнд хийж байгаа

⁶ Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 117 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны стратеги”, 15 дугаар хуудас, хүснэгт 5.

ажлаа үргэлжлүүлэх, энэ чиглэлээр эдийн засгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын болон Их хурлын харьяа байгууллагуудтай хамтарч ажиллах шаардлагатай. Нөгөөтэйгүүр, эдийн засгийг хямралаас хамгаалах хамгийн чухал арга зам бол дотоодын эдийн засгийн салбар, үйлдвэрлэлийг хөгжүүлж, аж үйлдвэрлэлийн чадамжийг нэмэгдүүлж, бусадтай хийж буй худалдаа, валютын урсгалыг тэнцвэржүүлэхэд орших юм. Иймд, Засгийн газраас хэрэгжүүлж буй экспортыг болон дотоодын үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээ нь эдийн засгийн үр ашигтай хөрөнгө оруулалт байх ёстой.

- ***Төсөв, мөнгөний бодлогын уялдаа хангалтгүй.*** макро эдийн засгийн хоёр бодлогын хувьд аваад үзвэл мөчлөг сөрсөн байдлаар томъёологдож байгаа хэдий ч бодит гүйцэтгэлийг нь аваад үзвэл хоёулаа нилээд тэлэлттэй явагдаж иржээ. Энэ нь эдийн засагт халалт үүсгэж улмаар тогтворгүй байдлыг бий болгох байдал ажиглагдаж байна. Гэтэл, энэхүү үүсээд байгаа эдийн засгийн тогтворгүй байдал нь макро эдийн засгийн бодлогын уялдаа хангагдахгүй байгааг харуулж байна. Төсөв, сангийн бодлогын хэт тэлэлт нь эдийн засаг дах нийт эрэлтийг өсгөж улмаар инфляцын түвшинг өсгөх нөлөөг үзүүлж ирсэн. Гэтэл, энэ үйл явц инфляцыг онилоод байгаа мөнгөний бодлогын нөлөөг сулруулж байгаа. Өөрөөр хэлбэл, төв банкыг илүү хатуу мөнгөний бодлого авч хэрэгжүүлэхэд хүргэж байсан нь бидний хэлэлцэж буй уялдаа алдагдаж буй жишээ юм. Нөгөө талаасаа мөнгөний бодлого инфляцийг бууруулах зорилгын хүрээнд илүү мөнгөний хумих бодлого баримталж байгаа боловч алт худалдан авах, гүйлгээнд шинэ мөнгө хэвлэн гаргах зэрэг нь мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.
- ***Төсвийн зарлагын менежментийг боловсронгуй болгох, үр ашгийг сайжруулах чиглэлээр шинэчлэл хийх асуудал өнөөдрийн томоохон сорилт болоод байна.*** Үүний тулд төсвийн зохицуулалтыг илүү оновчтой болгож, урьдын тэлэлт, агшилтын мөчлөг дахин давтагдахаас сэргийлэн, засгийн газрын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үр ашигтай хэрэгжүүлэх чадавхи, эдийн засгийн шингээх хүчин чадалд нийцүүлэн төсвийн зарлага санхүүжилтийн өсөлтийг тогтоох хэрэгтэй. Төсвийн зарлага санхүүжилт эрдэсийн орлогын богино хугацааны хэлбэлзэлээс аль болох ангид байлгах ёстой. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиар тогтоосон тусгай шаардлагуудыг хангаж, төсвөөс гадуурх санхүүжилтийн механизм ашиглахгүй байх нь ойрын хугацаанд хийж гүйцэтгэх ажил юм. Төсвийн алдагдалыг бууруулах зөв зүйтэй төлөвлөгөө гарган ажиллаж, 2013 онд төсвийн алдагдалыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд заасан хязгаарт багтаах нь зүйтэй.
- ***Урсгал төсөв, хөрөнгийн зарлагын төлөвлөлт тусдаа хийгдэж байгаа нь нэгдсэн төлөвлөлт хийхэд хүндрэл учруулж байна.*** Дотоодын хөрөнгө оруулалтын зардал ихээхэн хэмжээгээр нэмэгдэж байгаа нь төсвийн үр ашигтай, үр дүнтэй төлөвлөлт болон хэрэгжилтийн ач холбогдлыг бууруулах талтай байна. Нэгдсэн Төсвийн Тухай Хууль нь (НТТХ) төслийг бэлтгэх, үнэлэх тал дээр зохицуулалтыг бэхжүүлэх, болон төлөвлөлт болон хөрөнгийн төсвийн хоорондох зохицуулалтыг сайжруулахад томоохон алхам болсон. Гэвч НТТХуулийг хэрэгжүүлэхэд ихээхэн ажил хийгдэх хэрэгтэй. Эдийн Засгийн Хөгжлийн Яам (ЭЗХЯ) болон Сангийн Яамны (СЯ) одоогийн чадавхи, хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлсэн ч эрх яамдын хооронд хөрөнгийн болон урсгал зардлуудад тавих үүрэг хариуцлагуудыг хуваасан нь төслийг үр ашигтай бэлтгэх болон хяналт тавихад саад учруулж байх талтай. Засгийн газрын одоогийн хязгаарлагдмал чадавхид тохируулан байгаа нөөцөө хамгийн үр ашигтай ашиглах илүү амьдралд ойрхон, бодитой аргыг хэрэгжүүлэх нь зүйтэй ⁷.
- ***Монгол Улсын стратеги төлөвлөлт, бодлогын баримт бичгүүд нь Улсын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй уялдаагүй байна.*** Монгол улсад өнөөдрийн байдлаар УИХ-аас баталсан урт болон дунд хугацааны бодлогын баримт бичиг 38, Засгийн газраас хэрэгжүүлж байгаа үндэсний хэмжээний хөтөлбөр 120 байна. Олон улсын байгууллагуудаас өгсөн

⁷ Дэлхийн банк

үнэлгээгээр манай улсын хөрөнгө оруулалтын төлөвлөлт нь бодлоготой уялдаагүй, үндсэн хөрөнгийн засвар, урсгал зардлыг хөрөнгө оруулалтад бүрэн тусгадаагүй, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь зөвхөн улсын төсөв, хөгжлийн сангаас санхүүжих төслийн жагсаалт хэлбэртэй, хөрөнгө оруулалтын зохицуулалт, байгууллага, хүний нөөцийн чадавхи сул маш олон дутагдал оршиж байгааг шүүмжлэн анхааруулдаг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөж, хэрэгжүүлж ирсэн байдал нь тухайн төслийг хэрэгжүүлснээс улс орны эдийн засагт үзүүлэх үр ашгийн тооцоо судалгаагүй, зөвхөн “амлалт”-ыг биелүүлэхэд чиглэж, улс орны хөгжлийн нийтлэг хандлага, хөрөнгө мөнгийг хамгийн үр дүнтэй зарцуулахад чиглэгдэхгүй байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалт 2000 оноос хойш тогтмол өсч байгаа боловч хөрөнгө оруулалтын өгөөж нь хувийн хөрөнгө оруулалтаас 1.75 дахин бага байна гэж судалгаагаар гарчээ. Макро эдийн засаг сүүлийн үед огцом өөрчлөгдөж байгаа ч эрдэс баялгийн нөөцийг бодит болон хүний капитал хөрөнгө болгон хувиргахын тулд Монгол улс нь төсвийн бодлого, төлөвлөлт, төсөвлөлтийн шинэчлэлт хийх шаардлагатай байна. Олон улсад хэмжээнд түгээмэл хэрэглэгдэж байгаа “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Эдийн засгийн огцом өсөлттэй жилүүдэд шинэ хөрөнгө оруулалт түргэн нэмэгдэж, тухайлбал 2008 онд 2005 оноос 9 дахин их хөрөнгийн үндсэн хөрөнгө оруулалт хийжээ. Энэхүү зарлагын түргэн өсөлт нь төлөвлөлт, гүйцэтгэлийн системтэй уялдаагүйгээс хөрөнгийг зарим буруу хуваарилалт гарч, улмаар хэрэгжилтийн ажил удааширах зэрэг олон асуудал гарч байлаа. Монгол Улсын төсөв нь их ба урсгал засварт бага хөрөнгө хуваарилж байгаагаас үндсэн хөрөнгийн ашиглалт, чанар муудаж байна. Монгол Улсад хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах тогтолцоо байхгүй байна. Одоогийн төлөвлөлт, төсөв гаргах журмууд нь хэт ерөнхий, санал болгож байгаа төслүүдтэй цуг эдийн засгийн болон санхүүгийн ямар дүн шинжилгээ хийх ёстой, эдгээр төслүүдийг үнэлэх үндэслэл нь юу байх талаар тодорхой зааж өгсөн зааварчилгаа байхгүй байна. Эдгээр аргагүйгээр салбар хоорондын болон салбаруудын эрэмбийг тодорхойлох, мөн аль нь сайн, аль муу төсөл вэ гэдгийг тодорхойлоход хэцүү байх болно.

Төрөөс хувийн хэвшлийг дэмжих бодлого тодорхойгүй, төрийн оролцоо өндөр, хүнд суртал, шат дамжлага их байна.

- ***ЖДҮ-г хөгжүүлэх чиглэлээр нэлээд бодлогын баримт бичгүүд, хууль гарсан боловч хэрэгжилт хангалтгүй, санхүүжүүлэх механизм боловсронгуй бус шат дамжлага их байна.*** Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль нь 2007 оны 7 дугаар сарын 27-нд батлагдснаар маш чухал алхам болсон. Гэвч, Хууль батлагдах үед хуулийн үзэл баримтлалд тусгаж санал болгож байсан гол зүйлүүд хуулинд тусгагдаж өгөөгүй нь өнөөдрийг хүртэл хууль хэрэгжүүлэх хяналт тавихад хүндрэл учруулж байна. Энэ хууль нь суурь хууль буюу ерөнхий хуулийн хэмжээнд батлагдаж чадаагүй, мөн бичил үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгч, жижиг үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгч, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгч гэсэн үйл ажиллагааны үндсэн салбаруудаар нь тодорхой зааж өгөх тухай тусгаж байсан хэдий ч хуулинд тодорхойгүй байдаг нь хуулийг хэрэглэх нийтээр дагаж мөрдөхөд хүндрэл үүссээр байна. Бодлого, үндсэн чиглэлийг тусгасан хуулийн гуравны нэгтэй тэнцэх тунхаглалын шинжтэй заалтууд байгаа нь /Тавдугаар бүлэг/ хуулийн хэрэгжилт хангалтгүй гэх гол шалтгаан болж байна. Тунхаглалын шинжтэй заалтуудад бизнесийн шинэчлэл, шинээр бизнэс эрхлэх болон бүтээлч үйл ажиллагааг дэмжих, менежментийн нөөц, бизнес эрхлэх таатай нөхцлийг бүрдүүлэх замаар менежментийн үндэс суурийг бэхжүүлэх, менежментийн тогтвортой байдлыг хангах, бизнесийг хувирган өөрчлөх боломжийг бүрдүүлэх замаар эдийн засаг, нийгмийн өөрчлөлтөд зохицох чадварыг нэмэгдүүлэх, санхүүжилтийг дэмжих, өөрийн хөрөнгийн хангалттай байдлыг сайжруулах тухай заалтууд байгаа хэдий ч хэн, хэрхэн яаж хэрэгжүүлэх нь тодорхойгүй байгаа юм.

- **Монголд санхүүгийн зуучлал хурдацтай өсч байгаа ч аж ахуйн байгууллага тухайлбал, бичил, жижиг дунд үйлдвэрт (БЖДУ) санхүүгийн хүртээмж багатай хэвээр байна.** Аж ахуйн нэгжийн судалгаагаар аж ахуйн нэгжүүдийн хувьд тохиолддог 10 том бэрхшээлийн нэгээр санхүүгийн хүртээмжийг гэж нэрлэсэн. БЖДУ-д ДНБ-ний 25 хувийг үйлдвэрлэж, ажиллах хүчний тэн хагас ажилладаг. Гэвч тэд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, цаашдын өсөлтөнд дэмжлэг болох санхүүгийн нааштай нөхцөлөөр хангагдаагүй байна. БЖДУ-ийн зээл нь харьцангуй өндөр хүүтэй, хугацаа богинотой, хэмжээний хувьд бага бөгөөд үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан байх шаардлагыг тавьдаг. Нийлүүлэлтийн талаасаа банкууд богино хугацаат хадгаламжийн бүтэцтэй, урт хугацаат санхүүжилтийн бусад эх үүсвэр дутагдалтай байна.
- **Засгийн газраас ЖДҮ-г дэмжих чиглэлээр маш олон эх үүсвэрээр хөнгөлтэй зээл олгож байгаа нь нөөцийн оновчтой хуваарилалт, үр ашигт сөргөөр нөлөөлж байна.** Засгийн газраас ЖДҮ-г дэмжих сан, засгийн газрын бонд, сум хөгжүүлэх сан, ноос ноолуур хөтөлбөр(ЗГ-н бонд), орон нутгийн зээл, бүсийн хөгжлийн зээл, “Сүү” хөтөлбөр, “Түүхийн эдийн төв байгуулах хөтөлбөр” хөтөлбөр зэрэг маш олон эх үүсвэрээс 400 гаруй тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд үүний үр дүн, үр ашиг ямар байгаа цаашид санхүүжилтийн тогтолцоог хэрхэн боловсронгуй болгох чиглэлээр бодлогын арга хэмжээ авах шаардлагатай. Төрийн байгууллагууд ялангуяа гааль, татвар, мэргэжлийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагааг шуурхай, хүнд сурталгүй, нээлттэй болгох асуудал нэн чухал байна. Жижиг үйлдвэрийн дунд, дундыг том болгох зах зээлийн эрүүл орчинг бүрдүүлэхэд ЖДҮ бодлого чиглэж үүнийг үр дүн эдийн засаг өмнөхөөс илүү төрөлжсөн байдалтай болвол макро эмзэг байдал, гадаад орчноос хэт хамааралтай байдал, гадаад болон дотоод /улс төрийн/ шоконд өртөмтгий байдал буурах сайн үр дагавартай байх болно. Эдийн засаг бүхэлдээ дан ганц гадаад эрэлтээс хамааран өсч байна. Түүний үр дагавар нь эдийн засгийн макро дархлаа сулрах гол шалтгаан Голланд өвчний сөрөл нөлөө улам даамжирах байдал бүрдэх юм. Дотоод эрэлтийг урамшуулах, бизнесийн орчинг сайжруулах, эдийн засгийн өсөлтийн хүртээмжтэй болгох арга хэмжээ авах шаардлагатай. ЖДҮ-г дэмжих чиглэлээр Олон улсын байгууллага болон Засгийн газраас гаргаж буй санхүүгийн эх үүсвэрийг хуваарилах тогтолцоог олон улсын туршлагад суурилан аль болох Улс төрийн болон Засгийн газрын оролцоо багатай “Жижиг дунд үйлдвэрийн банк” байгуулах асуудлыг ч судалж үзэх шаардлагатай болж байна.
- **Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээр дамжуулан эдийн засагт оролцож буй төрийн оролцоо өндөр , үр ашиг харьцангуй бага, менежмент сул байна.** Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа, бизнес регистрийн санд бүртгэлтэй 51940 ААН байгаагаас, төрийн өмчит ААН- 4598, хувийн хэвшлийн ААН-47342 байна. 2012 оны байдлаар Төрийн өмчийн хороонд бүртгэлтэй, 50%-иас дээш төрийн оролцоотой, эдийн засагт нөлөө бүхий 91 томоохон аж ахуйн нэгж байгаагаас, төрийн өмчийн оролцоотой ААН-4, Хамтарсан үйлдвэр-6, төрийн өмчит ХК-43, ХХК-5, төрийн өмчит үйлдвэрийн газар-33 байна. Эдгээр ААН-үүд нийтдээ 2 871,0 тэрбум төгрөгийн борлуулалт хийж 300.5 тэрбум төгрөгийн ашигтай ажилласнаас нийт борлуулалтын 62.1 хувийг буюу 1792.5 тэрбум төгрөгийг Эрдэнэт үйлдвэр, Монросцветмет нэгдэл, Монголын цахилгаан холбоо компани зэрэг хамтарсан үйлдвэрүүд бүрдүүлж 307,6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ. Нийт төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн 38 нь буюу 41.7 хувь нь / МИАТ компани, Багануур, Шивээ овоогийн уурхай, дулаан, цахилгаан дамжуулах сүлжээ компаниуд, Мэдээл холбоо сүлжээ компани, Монсам ХХК хамтарсан үйлдвэр зэрэг аж ахуйн нэгжүүд 34.0 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Алдагдалтай аж ахуйн нэгжүүдийг бүтцээр нь судалж үзвэл нүүрс олборлож дотоодын зах зээлийг хангадаг томоохон компаниуд, цахилгаан, дулаан дамжуулах сүлжээнүүд зонхилж байгаа нь тэдгээрийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг төрөөс тодорхой хэмжээнд зохицуулж байгаатай холбоотой байна. Багануур компаний борлуулалтын

орлого нь үйлдвэрлэлийн өртгийн 92.4 хувийг нөхөж байгаа бол Шивээ овоо компаний үйлдвэрлэлийн өртөг нь борлуулалтын орлогоосоо 5.1 хувиар давж байна. Энэ нь эдгээр компаниудын борлуулалтын орлого нь үйлдвэрлэлийн зардлаа нөхөж хүрэлцэхгүй, үйл ажиллагааны зардлыг нөхөх эх үүсвэргүй байна. Төрийн өмчийн оролцоотой компаниудын бүтцийг авч үзвэл улс орны эдийн засагт мэдэгдэхүйц нөлөө бүхий томоохон аж ахуйн нэгжүүдээс гадна Автоимпекс компани, Кино урлагийн дээд сургууль, Монсам ХХК, Оргил рашаан сувилал, Харгуй, Талын зам ХХК зэрэг үйл ажиллагааны чиглэл, ач холбогдол нь тодорхой бус байгууллагууд ч байна. Түүний зэрэгцээ төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлж байгаа аймгууд дахь Цөм сүргийн үржлийн аж ахуй, Геологийн судалгааны төв, Геологийн төв лаборатори, Сэргээгдэх эрчим хүчний төв зэрэг төрийн өмчийн үйлдвэрийн газрууд байгаагийн дотор ИНЕГ, Аялал жуулчлалын үндэсний төв, Сэргээгдэх эрчим хүчний төв зэрэг байгууллагууд байна. Төрийн оролцоотой аж ахуйн байгууллагуудын үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, засаглалын тогтолцоог боловсронгуй болгох зайлшгүй шаардлага байна.

Тав. БАЙГАЛЬ ОРЧИН НОГООН ХӨГЖИЛ, ЭРҮҮЛ МЭНД, ЯДУУРАЛ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ БУСАД АСУУДЛУУД⁸

- **Байгаль орчин, ногоон хөгжилийн бодлого нэн чухал анхаарал хандуулах асуудал болж байна.** Монгол улс нь олборлох, түүхий эдийн экспортод тулгуурласан, эрчим хүч, түүхий эд, нөөцийн хэрэглээний үр ашиг муу, үйлдвэрлэлийн технологи хоцрогдмол, хаягдал ихтэй, орчинд бохирдол ихээр гаргадаг хүрэн эдийн засагтай байна. Эрс тэс уур амьсгалтай, эдийн засгийн хөгжил нь байгалийн нөөц баялгийн олборлолтод тулгуурласан манай орны хувьд эдийн засгийн голлох салбаруудаа "хүрэн" эдийн засгаас "ногоон" эдийн засагт шилжүүлэх үзэл баримтлал түүнийг мөрдөх арга зам нь өөрийн өвөрмөц онцлогт тулгуурлах шаардлагатай. Өргөн уудам нутаг, цөөн хүн амтай манай орны хувьд ногоон эдийн засагт шилжих эрх зүй, бодлогын орчныг яаралтай бий болгож чадах аваас ногоон эдийн засгийг хөгжүүлэх боломжтой болно. Манай орны эдийн засгийн голлох салбарууд хөгжлийнхөө эхлэлийн шатанд байгаа болон ашигт малтмалын арвин их нөөц баялагтай, дэлхийн томоохон зах зээлд ойр байрлалтай байгаа зэрэг нь харьцангуй давуу тал гэж үзэж байна. Мөн газар нутгийн дийлэнх хэсэг нь байгалийн унаган төрхөөрөө байгаа нь бидэнд илүү боломжийг олгож байна. Хэрэв Монгол улс өөрийн давуу байдлыг ашиглан, шаардлагатай эрх зүй, бодлого, зохицуулалтыг амжилттай хэрэгжүүлж чадваас ногоон эдийн засгийн загварыг амжилттай хөгжүүлж, дэлхийн олон нийтэд үлгэр жишээ болох боломжтой юм.
- **Эрүүл мэндийн салбарын зардал өсч байгаа боловч үр дүн, үр ашиг муутай, менежемент сул, мөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хангалтгүй байна.** Шинжлэх ухаан, технологийн дэвшилд тулгуурласан эмчилгээний шинэ технологи, багаж төхөөрөмж, эм урвалж үйлчилгээнд нэвтрэхийн хэрээр эрүүл мэндийн зардал өсөж байгаа нь улс орны түвшинд шийдвэрлэвэл зохих эдийн засгийн нэн чухал асуудал болж байна. Нөгөө талаас *албан бус төлбөрт үйлчилгээ нэмэгдэж байгаа нь ядуурал өндөртэй манай орны хувьд хүн амын санхүүгийн дарамтыг улам бүр нэмэгдүүлэх хандлагатай болж байна.* Мөн ДЭМБ-ын Ази, Номхон далайн бүсийн Эрүүл мэндийн санхүүжилтийн стратеги (2010-2015) нь бүх гишүүн орнууддаа хувь хүн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах үедээ төлөх төлбөр нь эрүүл мэндийн нийт зардлын 30-40 хувиас хэтрэхгүй байх, эрүүл мэндийн улсын зардлын ДНБ-д эзлэх хувийн жин 4-5 хувиас багагүй байхыг зөвлөмж болгосон. 2012 оны байдлаар авч үзэхэд

⁸ Ажлын хэсгийн гишүүдийн саналаар нэмж оруулсан

эрүүл мэндийн нийт зардал 520.5 тэрбум болж 2011 оныхоос 33 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн хэдий ч ДНБ-д эзлэх хувь 4.3 байснаа 2.9 хувь болж буурсан үзүүлэлттэй байна. Улсын төсөв болон эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийн тогтолцоо нь боловсронгуй бус эрүүл мэндийн салбарын бодлого, тусламж үйлчилгээний чанартай уялдахгүй эмнэлгийн урсгал зардлыг санхүүжүүлэхэд чиглэгдэж байна.

- **Ядуурал.** Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны дүнгээр 2012 онд ядуурлын түвшин 27.4 хувь, ядуурлын гүнзгийрэлт 7.1 хувь, ядуурлын мэдрэмж 2.7 хувь болов. Ядуурлын хамралтын хүрээг бүс нутгаар авч үзвэл Хангайн бүсэд 38.6 хувь, Зүүн бүсэд 33.3 хувь, Баруун бүсэд 32.5 хувь, Төвийн бүсэд 28.1 хувь байна. Ядуурлын түвшин 2012 онд хөдөөд 39.8 хувь, аймгийн төвд 30.4 хувь, сумын төвд 27.5 хувь, нийслэл хотод 19.8 хувь байна. 2011 онд 2010 онтой харьцуулахад Хүний хөгжил сангаас иргэдэд олгосон хишиг хувь 2.7 дахин өссөн, 2012 онд хүүхдийн мөнгө (сар бүр 20000 төгрөг) олгосон, ажиллагчдын сарын дундаж цалин 31.4 хувиар, нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 60.2 хувиар нэмэгдсэн зэрэг нь ядуурал буурахад эерэгээр нөлөөлсөн байна. Мөн 2009-2010 оны зудын хүндрэл бэрхшээлийг даван туулж, 2011, 2012 онд цаг агаарын таатай нөхцөл байдлаас үүдэн малын тоо толгой өссөн нь ядуурал буурахад тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлжээ. Гэвч энэхүү түр зуурын арга хэмжээ нь дунд хугацаанд инфляцийг өсгөх, ажилгүйдэлийг нэмэгдүүлэх зэргээр сөргөөр нөлөөлж байна. *Нэн тэргүүний сорилт бол нийтийг хамарсан нийгмийн халамжаас зорилтот бүлэгт чиглэсэн халамжийн бодлогыг хэрэгжүүлэх болоод байна..*

- **Зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг 2013 оны Төсвийн тухай хуулиар баталнаас одоогийн байдлаар 100 гаруй төсөл арга хэмжээ цаг хугацаандаа хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүсээд байна.** Засгийн газрын худалдан авах ажиллагаа нь дотоодын нийт бүтээгдэхүүний 15-20 хувийг эзэлдэг эдийн засгийн чухал бүрдэл бөгөөд Монгол Улсын хэмжээнд дараах гурван төвшинд худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Үүнд:

1. Улсын төсвийн төвлөрсөн зардлаас буюу урсгал зардлаас санхүүжих худалдан авах ажиллагааг бүх шатны төсвийн байгууллагууд хуулийн 45.1-д заасан захиалагчийн эрх, үүргийн дагуу зохион байгуулахаас гадна өөрийн хэрэгцээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд хуулийн 45.2.1-т заасны дагуу;
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тухайн орон нутагт худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд болон тухайн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжигдэх бараа, ажил, үйлчилгээний хувьд хуулийн 45.2.1-т заасны дагуу орон нутгийн худалдан авах ажиллагааны алба;
3. Улсын болон бүсийн чанартай Засгийн газраас баталсан төсөл, арга хэмжээний хувьд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Худалдан авах ажиллагааны газар зэрэг болно.

Мөн үндэсний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор дотоодын аж ахуйн нэгжид давуу эрх олгох талаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд тусгасан бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагчид тендерийн баримт бичиг боловсруулахдаа заавал дотоодын давуу эрх олгох талаар чиглэл өгч ажиллах боломжтой юм.

Түүнчлэн тус хууль мөрдөгдөж эхэлснээс хойш тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцсон тохиолдол харьцангуй бага байгаа нь судалгаанаас харагдаж байна. Жишээлбэл, Зам тээврийн яамнаас сүүлийн 3 жил зарласан нийт тендер шалгаруулалтад гүйцэтгэгчээр шалгарсан аж ахуй нэгжүүдийн 3 хувь, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зарласан

тендер шалгаруулалт хувьд 0,01 хувийг эзэлж, бусад байгууллагаас ирүүлсэн судалгаагаар гадаадын этгээд гүйцэтгэгчээр шалгараагүй байна.

Худалдан авах ажиллагааны шинэ тогтолцоо хэрэгжиж эхэлснээр дараах хүндрэл учирч байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг оновчтой хийгээгүйн улмаас зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт боловсруулагдаагүй төсөл, арга хэмжээ тухайн оны төсвийн тухай хуульд тусгагдснаас төслийн хэрэгжилт удаашрах, худалдан авах ажиллагаа зохион байгуулагдахгүй байх;
- Магадлал хийгдсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг нь Төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт өртөгөөс хэтрэх;
- Тендерт оролцогчдын хууль эрх зүйн талаарх мэдлэг сул зэрэг хүндрэл бэрхшээл тулгарч байна.

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “Засгийн газрын худалдан авах ажиллагааг 100 хувь цахим болгох” тухай тусгагдсан тул тендерт оролцогчдийн чадавхийг сайжруулах сургалтуудыг зохион байгуулах, техник, технологийн шинэчлэлийг хийх шаардлагатай юм. Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулах, зураг төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт нь батлагдсан төсөл арга хэмжээг Төсвийн тухай хуульд тусгаж байхыг онцгой анхаарах нь зүйтэй байна.

Мөн “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон “Концессийн тухай” хуулийн уялдааг сайжруулах зорилтын хүрээнд дээрхи хуулиудад нэмэлт өөрчилөлт оруулах шаардлага гарч байна (Дэлгэрэнгүйг хавсралт-10-аас харна уу).

---oOo---

